



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/Ч89

Арвайхээр

Улсын үзлэг зохион байгуулах, хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5. "е", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 243 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний тав дахь хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.7.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2021 төсөв батлах тухай" 03/07 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг эрчим хүчний салбарт зохион байгуулах аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, улсын үзлэг болон Нэн тэргүүнд ХАБ-21 сургалтын зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 445,400 (дөрвөн зуун дөчин таван мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Улсын үзлэгийг сайтар зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, тайланг нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэг (Б.Загдзэсэм)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101038

Аймгийн Засаг даргын 2020 оны 10
дүгээр сарын 19-ны өдрийн 4/1489 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН УЛСЫН ҮЗЛЭГ
БОЛОН "НЭН ТЭРГҮҮНД ХАБ-21" СУРГАЛТЫН ЗАРДАЛЫН ТООЦОО

Д/д	Сумын нэр	Үзлэгт хамрагдах байгууллагын тоо	Албан томилолт	Шатахууны нийт зардал
1	Арвайхээр	2	0	Дотор явах 10 л*2100= 21000
2	Хархорин	2	5 хүн*1 хснэг*12000=60000	Нийт явах 140*2=280км 56 л*2100= 117600
4	Бичиг хэргийн зардал			16000
НИЙТ				214600
НЭН ТЭРГҮҮНД ХАБ-21 СУРГАЛТЫН ЗАРДАЛ (2 өдрөөр)				
№	Шаардагдах материал	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Цайны зардал	44	3700	162,800
2	Ус	44	1000	44,000
3	Кофе	2 уут	12000	24,000
Нийт				230,800
БҮГД				445,400